



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/116

Эрдэнэт


Г Тэмцээний зардалд хөрөнгө гаргах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5./а/ , 29.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит 4 дүгээр хуралдааны 01 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 03 дугаар сарын 19-25-ны өдрүүдэд Солонгос улсын Дэгү хотод зохиогдох Хөнгөн атлетикийн ахмадын заалны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол улсыг төлөөлж оролцох Орхон аймгийн ахмад тамирчин, Ази тивийн аварга, Монгол улсын спортын мастер Ч.Баатаржавын зардалд 1000000 /Нэг сая/ төгрөг, 2017 оны 04 дүгээр сарын 21-29-ний өдрүүдэд Шинэ Зеланд улсын Окланд хотноо зохион байгуулагдах Хөнгөн атлетикийн ахмадын дэлхийн тоглолтод Монгол улсыг төлөөлөн оролцох 3.Чулуунбаатарын зардалд 1000000 /Нэг сая/ төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсүгэй.

2.Шаардагдах зардал 2000000 /Хоёр сая/ төгрөгийг Засаг даргын нөөц сан хуваарилагдаагүй бусад зардлын жагсаалтын "Соёл, спорт, хүүхэд залуучууд, олон нийтийн арга хэмжээг жилийн туршид зохион байгуулах арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д. БАТЛУТ